



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/296

Алтай хот

Сонгон шалгаруулалт зохион
байгуулах хороог байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.23 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/565 дугаар тушаалаар баталсан журмын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчит Нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг нэр дэвшүүлэн сонгох хурлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Мөнхжаргал -(Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Ч.Эрдэнэбулган-(аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл, төлөөлөгч хариуцсан ахлах мэргэжилтэн)

Т.Ууганжаргал -(аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хууль, эрх зүй хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн)

О.Мягмарбодь -(Эрүүл мэндийн газрын хүний нөөц хариуцсан мэргэжилтэн)

Д.Ганчимэг -(Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн чанар төлбөрийн мэргэжилтэн)

Г.Батбаяр -(Нэгдсэн эмнэлгийн нүүр ам судлалын их эмч)

Нарийн бичгийн дарга: Э.Анхтөр -(Эрүүл мэндийн газрын хуулийн зөвлөх)

2.Нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийг журмын дагуу сонгон шалгаруулж, тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (С.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогддуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/22 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

0201000959